



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 08

Бор-Өндөр сум

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ
ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Бор-Өндөр сумын сонгуулийн хорооны 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд Бор-Өндөр сумын 21-18-2, 21-18-3 дугаар тойрогт нэр дэвшиж хамгийн олон санал авсан Санчир овогтой Угтахбаяр, Базар овогтой Оюун-Эрдэнэ нарыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсугай.
2. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, иргэд сонгогчдынхоо төлөө идэвх зүтгэлтэй ажиллахыг төлөөлөгчдөд даалгасугай.

ДАРГА



Э.МӨНХ-ЭРДЭНЭ